

Босоо амны нэвтрэлт

Гүний уурхайн барилга байгууламж

Өгсөж өрөмдөх нэвтрэлт /Рэйзбоор/

Уурхайн олборлолтын ажлыг
гэрээлэн гүйцэтгэх

Дээшээ малталт нэвтрэлт /Алимак/

Гүний уурхайн үндсэн малталт,
нэвтрэлт

Инженерийн болон техникийн
үйлчилгээ

Аюулгүй ажиллагаа болон сургалт





“ДАЯН КОНТРАКТ МАЙНИНГ” ХХК нь Монгол улсад олон жил үйл ажиллагаагаараа танигдсан, салбартаа тэргүүлэх туршлагатай “Рэдпаф Монгол” ХХК болон “Хасу Мегаватт” ХХК-уудын хамтарсан компани болж, 2015 онд албан ёсоор үүсэн байгуулагдсан.

Одоогоор 1000 гаруй ажилтантайгаар Оюу Толгой төсөлд гүний уурхайн хэвтээ малталт нэвтрэлт, босоо амны нэвтрэлт, гүний уурхайн өргүүрийн барилга байгууламж, гүний уурхайн олборлолтонд бэлтгэх барилга угсралт, босоо амны цамхагийн тоноглол, том хэмжээт малталт, тоног төхөөрөмжийн суурилуулалт зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

2005 оноос эхлэн Оюу Толгой төслийн гүний уурхайн Нэгдүгээр босоо ам буюу Үйлчилгээний амны газрын дээрх барилга байгууламж (уурхайн өргүүр зэрэг) барих, босоо малталт нэвтрэлтийн ажлыг эхлүүлсэн бөгөөд:



- Үйлчилгээний амны (1-р Босоо ам) 1385 метр гүн нэвтрэлт гүйцэтгэл,
- Үйлчилгээний амны 1300 метрийн гүнд хэвтээ малталт нэвтрэлтийн гүйцэтгэл (туннель),
- Үйлдвэрлэлийн амны (2-р Босоо ам) 1284 метр гүн малталт нэвтрэлт гүйцэтгэл,
- Агааржуулалтын дунд амны (5-р Босоо ам) 1174 метр гүн малталт нэвтрэлтийн гүйцэтгэл,
- Дэлхийд хамгийн томд тооцогдох гүний уурхайн өргүүрийн байгууламжийн угсралт гүйцэтгэл


зэрэг томоохон төслүүдийг өөрийн сурган дадлагажуулж мэргэшүүлсэн уурхайчин залуусын нөр их хөдөлмөрийн үр шимээр амжилттай гүйцэтгэн ажиллаж байна.

Мөн Дорнод аймгийн нутагт орших Гурванбулагийн ураны гүний уурхайн илүүдэл ус шавхах, малталтуудыг сэргээх ажлуудыг амжилттай гүйцэтгэсэн.

Хамтран ажилладаг захиалагч компаниуд байгууллагууддаа бид чанарын өндөр түвшинд буюу тэдний хүлээлтээс давсан үйлчилгээ үзүүлэхийг үйл ажиллагааны тэргүүн зорилтоо болгон ажилладаг бөгөөд ажлыг төлөвлөсөн цаг хугацаанд нь аюул эрсдэлгүйгээр хийж гүйцэтгэхийг үргэлж эрмэлздэг.

БИДНИЙ ГҮЙЦЭТГЭЛ НАЙДВАРТАЙ - ИТГЭЖ БОЛНО





2004 онд “Рэдпаф Монгол” ХХК нь Монгол Улсад үүсэн байгуулагдсан бөгөөд Оюу Толгой төслийн гүний уурхайн бүтээн байгуулалтын ажилд туслан гүйцэтгэгчээр ажилласаар байгаа гүйцэтгэгч компани юм. Тус компани нь гүний уурхайн салбарт өдгөө 60 жилийн турш арвин их туршлага хуримтлуулсан Рэдпаф группийн гишүүн бөгөөд 2019 онд 15 жилийнхээ ойг амжилт дүүрэн тэмдэглэн өнгөрүүлсэн байна.

Рэдпаф Групп нь 6000 гаруй мэргэшсэн ажиллагсадтай бөгөөд дэлхийн бүх тивүүдэд, олон улс орнуудад гүний уурхайн бүтээн байгуулалт

олборлолтын нэвтрэлт, босоо амны нэвтрэлт, өгсүүр өрөмдлөг нэвтрэлт, хэвтээ малталт нэвтрэлт, инженерийн болон техникийн үйлчилгээ зэрэг олон төрлийн мэргэжлийн үйлчилгээг цогцоор нь хүргэдэг.

Олон улсад ажилласан туршлагынхаа хүрээнд Рэдпаф нь удирдан чиглүүлэх ур чадвар, тухайн бүс нутгийн онцлогт суурилсан ажлын туршлага болон байгууллагын соёлыг хөгжүүлэн хэвшүүлэх өргөн хэмжээний мэдлэгтэй, туршлагатай чадварлаг хамт олон юм.

“Хасу Мегаватт” ХХК нь 2000 онд байгуулагдсан бөгөөд Монгол Улсын Эрчим Хүч, Уул Уурхайн салбаруудад харьяалагдаж улмаар

- Эрчим Хүчний барилга байгууламж,
- Өндөр болон нам даралтын зуухнууд,
- Эрчим хүчний дэд системүүд,
- Механик ажлууд болон цахилгаан дамжуулах шугамууд,
- Инженерийн шугам хоолой,
- Даралтат сав болон тоног төхөөрөмжийн засвар, угсралт, ашиглалтын үйлчилгээнүүдийг үзүүлж ажиллаж байна

Хасу Мегаватт ХХК нь Төвлөрсөн дулааны байгууламж, дулаан дамжуулах шугам сүлжээ болон шугам хоолойн угсралт болон засварын ажлуудад нарийн мэргэшсэн.

Бид аюулгүй ажиллагааг нэн тэргүүнд тавьж, ослыг тэглэх бодлогыг баримтлан ажиллаж байна. Бид өөрсдийн хуримтлуулсан мэдлэг, туршлагаараа харилцагчдадаа бүтээгдэхүүн, үйлчилгээ тус бүрийн цогц шийдлийг санал болгож, ханган нийлүүлж, хамтран ажилладаг. Бидний дадлага туршлагатай ахлах ажилтнууд болон мэргэжилтнүүд олон улсын стандарт нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон шийдлүүдийг санал болгож, ханган ажиллана.

Бидний үзэл баримтлал



Рэдпаф Группийн үзэл баримтлал: Эрдийн нөхцөлд хүлээн зөвшөөрдөг стандартаас илүү өндөр хэмжээний үйлчилгээг уул уурхайн салбартаа үзүүлэх, Салбартаа бидний үйлчилгээг үргэлжлүүлэн авах хүсэл сонирхлыг бий болгох, Салбартаа өндөр чанартай үйлчилгээг тогтмол байлгаж, компанийн хөгжлийг хянах, “Сорилт бол амьдралын чухал нэгэн хэсэг.” гэсэн үзэл баримтлалыг 1962 оноос хойш Рэдпаф Групп итгэлтэйгээр баримталсаар ирсэн.



THE REDPATH GROUP
Mining Contractors and Engineers

Амжилтын гол үндэс



Бид үнэнч, шударга, хариуцлагатай. Бид төлөвлөгөө, төсвийг нарийвчлан боловсруулж гүйцэтгэлийг алдаагүй хэрэгжүүлэхийн төлөө мэрийдэг. Бид “Аюулгүй ажиллагаа - Эхэнд, Төгсгөлд ба Үргэлж” гэдэг зарчмаар ажилладаг. Бид өөрсдийн өрсөлдөгчдөө хэзээ ч шүүмжилдэггүй. Бид техникийн баримт бичгийг өндөр төвшинд боловсруулдаг. Бид мэдэхгүй зүйлээ асууж лавладаг. Бид захиалагч нартаа шилдэг үйлчилгээ үзүүлэх зорилттой. Шалтаг тоочих нь хүлээн зөвшөөрөшгүй асуудал. Бид компанийнхаа болон захиалагч нарынхаа урт хугацааны хамтын ашиг сонирхлын төлөө ажилладаг. Бид богино хугацааны ашигтай нөхцөлийг илүүд үздэг.

АЛСЫН ХАРАА

Дэвшилтэт технологи, мэдлэг туршлага шингээсэн ган хийц, эрчим хүчээр өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээг тасралтгүй хангагч, хөрөнгө оруулагч, нээлттэй нэгдэл болно.

ҮНЭТ ЗҮЙЛС


Аюулгүй ажиллагаа
Эерэг хандлагатай бүтээлч хамт олон
Сэтгэл ханамжтай харилцагч талууд
Бизнесийн ёс зүй
Тасралтгүй, тогтвортой хөгжил

ЭРХЭМ ЗОРИЛГО

Дэлхийд танигдсан чанар, үнэ цэнэ, цогц шийдэл – Хасу Мегаватт

ХАБЭА-Н БОДЛОГО

ХАБЭА-н холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн, эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлж, ажилтан нэг бүрийн болон сонирхогч талуудын эрүүл мэнд аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, тасралтгүй сайжруулна.



БОСОО АМНЫ НЭВТРЭЛТ

Бидний хамтрагч Рэдпаф нь гүний уурхайн босоо ам нэвтрэх туршлагаараа дэлхийн хэмжээнд, салбартаа тэргүүлэх байр эзэлдэг. Халуун орны ширэнгэн ой (Өмнөд Америк, Африк), тал хээрийн говь-цөл (Монгол, Киргиз), хэт өндөр уулархаг газар (Индонез, Перу), мөн хойд ба өмнөд мөсөн туйл (Аляска) зэрэг эрс тэс цаг агаарын нөхцөлд, дэлхий дээрх алслагдмал байршил руу Рэдпаф нь хүн хүч болон тоног төхөөрөмжүүдийг нүүлгэншилжүүлж, олон төрлийн босоо амыг найдвартай нэвтэрч, гүйцэтгэж чаддагаараа туршлагатай.

Рэдпаф нь аливаа улс орны хууль эрх зүй, ёс заншил, соёл уламжлалд маш хүндэтгэлтэй ханддаг бөгөөд түүн дээр тулгуурлан дэлхийн жишигт нийцсэн шинэлэг



арга барил, ур чадвар гарган аливаа төслийг концепц буюу санаа төдий хэлбэрээс эхлүүлэн инженерийн тооцоолол, улмаар бүрэн ашиглалтад оруулах хүртэл ажиллаж чаддаг бөгөөд энэ нь Даянд оруулж буй үнэтэй хувь нэмэр, мөн давуу тал юм. Энэ нь аливаа босоо амны инженерийн болон дизайны загварчлал гаргах, өргөх байгууламжийн зөв сонголт хийх, цаг хугацаандаа ашиглалтад оруулах бодит боломжийг олгодог.

Төслийг зөв, бодитойгоор төлөвлөснөөр хүлээлтээс илүү чанартай ажлыг гүйцэтгэж өгөх боломжтой болгодог. Энэ нь бидний хувьд маш чухал юм.

ГҮНИЙ УУРХАЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Даян Контракт Майнинг ХХК нь гүний уурхайн нэвтрэлт, барилга бүтээцийн болон угсралт суурилуулалтын ажлыг иж бүрдлээр нь бүтээн байгуулдаг. Гүний уурхайн дэд бүтэц, хүдэр буулгах болон дамжуулах системийн гүйцэтгэл ажлыг ерөнхий төсөөллөөс бүрэн ашиглалтад оруулах хүртэл манай туршлагатай мэргэжилтнүүд гүйцэтгэдэг. Дахин сэргээгдэж байгаа гүний уурхайд илүүдэл ус шавхах, хүдрийн дээж авах, сэргээн засварлаж шинэчлэн ашиглалтад оруулах зэрэг ажлуудыг гүйцэтгэсээр ирсэн.

Гүний уурхайн барилга байгууламж барих хүчин чадал болон үйлчилгээний цогц шийдлийн хүрээнд, өргөх байгууламж-өргүүр, дэд станц, агааржуулалтын систем, бусад механик суурилуулалт болон цахилгаан угсралтуудыг бүрэн гүйцэтгэдэг.





ӨГСӨЖ ӨРӨМДӨХ НЭВТРЭЛТ /Рэйзбоор/

“Рэдбоор” гэж нэрлэгдсэн цуврал загварууд буюу ах дүүс гэж нэрлэж болохоор өгсүүр өрөмдөж нэвтрэх зориулалттай тоног төхөөрөмжүүд бол Рэдпаф группийн дизайнаар зохион бүтээсэн өрмийн машин бөгөөд “Даян”-гийн төслүүд дээр ашиглаж байна. Эдгээр “Рэдбоорууд” нь бүрэн хэмжээний өгсөж өрөмдөх нэвтрэлтийг гүйцэтгэх бөгөөд, өөрийн онцгой хүчин чадал, зохимжит шийдэл бүхий загвартай.

Уг цуврал машинуудыг өгсүүр өрөмдөгчид өөрсдөө зохион бүтээсэн бөгөөд мэргэжил нэгтнүүддээ зориулан бүтээснээрээ онцгой машинууд гэдэгт эргэлзэх хэрэггүй. “Рэдбоор”-чууд маань алслагдсан нөхцөлд, цаг агаарын

эрс тэс уур амьсгалтай, хүнд нөхцөлтэй газар оронд очиж олон төсөл дээр амжилттай ажилласан арвин түүхтэй.

Бие даасан байдлаа илүү сайжруулахын тулд “Рэдбоор”-ыг тээвэрлэгч “Рэдтракс”-ыг (Redtrax) бүтээсэн бөгөөд энэ нь хамгийн орчин үеийн шийдэлтэй. “Рэдтракс” нь гүний уурхайд “Рэдбоор”-ыг тээвэрлэхээс гадна орчин нөхцөлдөө зохицон, үзүүлэлт бүхий гүний уурхайн бүх төрлийн сэрээт өргөгч, дугуйт ачигч зэргийг дэмжин ажиллах үүрэг гүйцэтгэж чадна.

УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН АЖЛЫГ ГЭРЭЭЛЭН ГҮЙЦЭТГЭХ

Бид түлхүүр гардуулах, эсвэл тусгай нөхцөлтэйгөөр гүний уурхайн ажлыг найдвартай гүйцэтгэж чадах ХҮНИЙ НӨӨЦТЭЙ, МЭДЛЭГТЭЙ, ТУРШЛАГАТАЙ. Бидэнд газар дээрх дэд бүтцийн барилгажилтанд ашиглах, гүний уурхайн олборлолтын үйлчилгээг үзүүлэхэд зориулсан тоног төхөөрөмжүүд байдаг.

Мөн түүнчлэн гүний уурхайн хүдэр зөөвөрлөх, бутлуур, дамжуурга, үндсэн их малталт, инженерчлэлийн тооцоолол зэрэг төслийн ажлуудыг эхнээс нь дуустал гүйцэтгэх бүрэн бололцоотой.





ДЭЭШЭЭ МАЛТАЛТ НЭВТРЭЛТ /Алимак/

Даян Контракт Майнингийн хамтрагч болох Рэдпаф (Redpath) нь 40 жилийн турш “алимак” төрлийн нэвтрэлтийг гүний уурхайн тоног төхөөрөмжийн хамгийн том үйлдвэрлэлтэй цогцлуулан шинэлэг бөгөөд патентлагдсан загвар, шийдлийн хүрээнд бүрэн үйлчилгээ үзүүлдэг. Тухайн үйлчилгээндээ тасралтгүй сайжруулалтыг хийсээр ирсэн бөгөөд ажиллах хүч болон тэдний гүйцэтгэлийн чанар, засвар үйлчилгээ, техникийн үзүүлэлтийн талаар өргөн мэдлэгийг хуримтлуулсан туршлагатай юм.

Уян хатан байдал, эдийн засгийн хэмнэлт болон малталтын хурд, дотоод засвар (үйлдвэрийн цехийн засвар), сургалтын материалын бааз

хэрэгсэл болон дараах үйлчилгээнүүдийг бид санал болгодог. Үүнд:

- Агааржуулалт
- Хүдэр гаргах малталт өрөмдлөг
- Малталтын чиглүүлэх өрөмдлөг
- Явган хүний гарц/Онцгой байдлын үеийн гарц
- Хүдрийн болон хүдрийн бус чулуулгийн ам
- Нарийн судлан олборлолт
- Малталтыг өргөсгөх


ГҮНИЙ УУРХАЙН ҮНДСЭН МАЛТАЛТ, НЭВТРЭЛТ

Даян Контракт Майнинг ХХК нь гүний уурхайн бүтээн байгуулалтын бүх төрлийн үйлчилгээг цогцоор нь хамгийн сүүлийн үеийн шийдлийн дагуу найдвартайгаар гүйцэтгэдэг. Үндсэн 300 гаруй хөдөлгөөнт тоног төхөөрөмж байх бөгөөд, үүнд:

- Жамбо өрмийн машин,
- Болтны машин,
- 17 тонн хүртэлх даацтай ачигч Эл Эйч Ди (LHD),
- 55 тонн хүртэлх даацтай өөрөө буулгагч машин, бусад хөдөлгөөнт туслах тоног төхөөрөмжийн иж бүрдэл орно.

Тухайн ажлын талбар дээрх тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийн ажлыг өөрсдөө зохион байгуулдаг бөгөөд, ингэснээр гарч болзошгүй хүндрэл болон зардлыг бууруулдаг.

Худалдан авалт, ложистик болон тээвэрлэлтийг олон жилийн туршлага дээрээ үндэслэн аль ч төслийн ханган нийлүүлэлтийг найдвартайгаар гүйцэтгэн ажилладаг.





АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА БОЛОН СУРГАЛТ

ТУРШЛАГА – МЭДЛЭГ – СУРГАЛТ
СУРГАЛТ – ДАДЛАГА – ТУРШЛАГА



Манай сургалтын хэлтэс нь гүний уурхайн босоо болон хэвтээ нэвтрэлтийн мэдлэг, ур чадварт суурилсан сургалтуудыг зохион байгуулж явуулдаг онцлогтой. Сургагч нар маань, Англи болон Монгол хэл дээр уурхайн тоног төхөөрөмжийн сургалтын материалыг Монгол Улсын болон олон улсын стандартад нийцсэн чанарын өндөр төвшинд боловсруулах, зааж сургахад бэлтгэгдэж


дадлагажсан чадварлаг хамт олон юм. Үүний хажуугаар бид хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн суурь сургалтууд, удирдах ажилтныг хөгжүүлэх манлайллын онол дадлага хосолсон сургалтуудыг хэрэгжүүлж байна.

Бид сургалтаа танхимаар явуулах, шууд ажлын байранд дадлага хийлгэх, ур чадварын нотолгоо шалгалт авах байдлаар төлөвлөн, хэрэгжүүлж, тасралтгүй хянаж, сайжруулах бодлого бариад зогсохгүй хоёрдогч шатны сургалтын баг бүрдүүлж уурхайчдын сургалтаар олж авсан ур

чадвар, ажлын бүтээмж, аюулгүй ажиллагааны хандлага, гүйцэтгэлийн чанар, талбар дээрх ажиглалт, үнэлгээний арга болон хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт дижитал технологи ашиглан хэмжигдэхүйц байдлаар тодорхойлж байна. Энэхүү аналитик мэдээлэл дээр тулгуурлан, ажилтнуудыг сайжруулах шаардлагатай дадал, ур чадвар тус бүрт тохирсон нэмэлт сургалт явуулах нь аюулгүй ажиллах туршлагыг нэмэгдүүлэх, өндөр үнэтэй тоног төхөөрөмжийг ариг гамтай, аюулгүй ашиглах дадал зуршлыг сайжруулах учиртай юм.

Мөн Даянгийн манлайлалд суурилсан “Коммон Кор” сургалтын баг хамт олон удирдах ажилтнуудаа олон улсын стандартын дагуу эрсдэлгүй, үр бүтээлтэй гүйцэтгэх шийдвэр гаргахад нь хувь нэмэр оруулахаар хичээнгүйлэн ажиллаж байна.





ИНЖЕНЕРИЙН БОЛОН ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Гүний уурхайн бүтээн байгуулалтаар 58 жилийн туршлагатай Рэдпаф компанийн мэргэшсэн буюу “профэшнл” инженерүүд, мөн техникийн үйлчилгээний баг нь нийт уурхайн байгууламжуудыг хамрах чадамжтай, туршлагажсан, шинэлэг, найдвартай, бүрэн зураг төсөл, загваруудыг санал болгодог.

Бидний мэдлэг, ур чадвар бол гүний уурхайн дэд бүтцийн бүх үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, бүтээх боломжтой бөгөөд үүнд:



- Бутлуурууд,
- Хөдөлгөөнт ажлын тавцан, гүний уурхайн хөнөгийн системүүд,
- Иж бүрэн өргөх байгууламжууд,
- Босоо амны засвар үйлчилгээнүүд,
- Босоо ам нэвтрэлтийн тусгай болон дэд бүтцүүд,
- Бараа тээвэрлэх систем,
- Хөндлөн болон ташуу малталт нэвтрэлтийн тэсэлгээний загвар,
- Гүний уурхайн иж бүрэн зураг төсөл, төлөвлөгөө

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

“Даян Контракт Майнинг” ХХК нь гүний уурхайн бүтээн байгуулалтад олон жил гар бие оролцон ажилласан, мэргэшсэн уурхайчдаар бүрдсэн үндэсний компани юм. Ажиллах хүчний 92 хувийг Монгол уурхайчин залуус бүрдүүлдэг бөгөөд гүний уурхайн хөндлөн малталт, барилга байгууламжийг байгуулах зэрэг ажлуудыг гэрээлэн гүйцэтгэж байна. Бид хүнээ хөгжүүлэх, чадавхжуулах тал дээр онцгойлон анхаардаг бөгөөд, гүйцэтгэлийг үргэлж сайжруулан шинэлэг арга барилыг тасралтгүй хөгжүүлсээр ирсэн. Тиймдээ ч салбартаа тэргүүлсэн гүний уурхайн мэргэшсэн үндэсний компани болон ажиллаж байна.

Нээлттэй байгаа ажлын байранд ажилтан сонгон шалгаруулж авахдаа өөрийн компанийн байранд тухайн ажилд орохыг хүссэн иргэний мэдээллийг авч улмаар ярилцлага хийх шаардлагатай гэж үзвэл өөрсдийн дотоод журмын дагуу зохих шалгалтыг авдаг. Мөн үүнтэй адил байдлаар хүний нөөцийн бүртгэл мэдээллийн санг бий болгодог.

Нээлттэй ажлын байрны зарыг өдөр тутмын хэвлэлээр мөн дараах цахим хуудасны (<https://onsite.dcm.mn/hr/vacancy>) хэсгээр зарладаг.



Бидний зорилго

Цаг хугацаа өнгөрөх тутамд бид амаргүй сорилтуудыг даван туулж, олон төрлийн орчинд дасан зохицсоор өнөөгийн нэр хүндийг бий болгосон. Хамт олон маань энэ амжилтын гол түлхүүр нь байсаар ирсэн бөгөөд шаргуу хөдөлмөр, хүчин чармайлтын үр дүнд компани улам бүр хөгжиж, хамт олноороо гар нийлэн ажилласаар байна.

Гүний уурхайн бүтээн байгуулалт нь бидний хийдэг зүйл бөгөөд, захиалагчдаа “Бидний гүйцэтгэл найдвартай - Итгэж болно” гэж амладаг. Өөрөөр хэлбэл – Даянд итгэ, бид танай төслийг эрсдэлгүй, ашигтай бөгөөд бодит үр дүнтэйгээр гүйцэтгэж өгөх болно.

Бид өөрсдийн үзэл баримтлал дээрээ тулгуурлан:

- Стандартаас илүү төвшний үйлчилгээг уурхайн салбартаа үзүүлэх;
- Урт хугацааны хамтын ажиллагааг хадгалах;
- Ажилтнуудынхаа ур чадварыг тогтмол сайжруулах бололцоогоор хангах;
- Салбартаа өндөр чанартай үйлчилгээг тогтмол үзүүлэхийн тулд шаардлагатай бүхий л сайжруулалтыг компанийнхаа хүрээнд хийх зэрэг үүрэг хүлээдэг.
- Бид энэхүү үзэл баримтлалыг итгэлтэйгээр мөрдөж ирсэн бөгөөд цаашдаа ч үргэлжлүүлсээр байх болно.

“Сорилт бол амьдралын чухал нэгэн хэсэг.”